



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1.4-т “Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.” гэж, 3.1.5-д “Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.7-д “Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.” гэж тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 174-т Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан зэрэг нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Нийгмийн халамжийн тухай хуулийг анх 1995 онд баталж, үүнээс хойш 1998, 2005, 2012 онд тус тус шинэчлэн найруулж байсан бөгөөд эдгээр хуулиудад хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийгмийн халамжийн чиглэлийн 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, 2010 он;
- Нийгмийн халамжийн тухай, 2012 он;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, 2016 он;
- Ахмад настны тухай, 2017 он;
- Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, 2017 он;
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, 2017 он.

Дээрх хуулиудын хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, алдар цолтой ахмад настан, олон хүүхэдтэй эх болон ядуу өрхийн гишүүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, онцгой тохиолдлын тэтгэмж, хүнсний эрхийн бичиг болон хүүхдийн мөнгө олгох, зорилтот бүлэгт олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, асрамжийн үйлчилгээ үзүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд орон сууцны хөлс төлөх, түлш худалдах авахад зориулан мөнгөн тусламж олгох, рашаан сувиллын үйлчилгээний хөнгөлөлт, протез, ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт үзүүлэх, “Алдарт эх” одонтой эхэд жилд нэг удаа тэтгэмж олгох, алдар цолтой ахмад настанд сар бүр нэмэгдэл олгох арга хэмжээнд 2019 онд нийт 668.2 тэрбум төгрөг зарцуулсан.

Нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулж байгаа хөрөнгө нь ДНБ-ний 2.1 хувь, хүүхдийн мөнгийг хасаж тооцвол ДНБ-ний 1.1 хувь болж байгаа нь бусад хөгжиж байгаа орнуудын нийгмийн халамжид зарцуулж байгаа дундаж зардалтай /ДНБ-ний 1.6 хувь/ харьцуулахад харьцангуй өндөр¹ байгаа юм. 2019 оны байдлаар нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулж байгаа хөрөнгө ДНБ-ний 2.0 хувийг эзэлж байна.

Монгол Улсын нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ нь хэт өргөн буюу жилд 840 гаруй мянган хүнийг хамарч, 4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт чиглээгүйг харуулж байна. Тухайлбал, 2015 онд Дэлхийн банкны судалгааны дүнгээс харахад нийт халамжийн үйлчилгээний 28 хувийг хүн амын амьжиргааны түвшин өндөртэй 40 хувь нь хүртсэн байна¹. Алдар цолтой ахмад настны нэмэгдэл нь 1 хүнд оногдох хэмжээгээр хамгийн өндөр боловч бараг бүхэлдээ ядуу бус иргэдэд очиж байна. Харин алдарт эхчүүдийн урамшуулал нь дөрөв ба түүнээс олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд насан туршид нь олгодог халамжийн төрөл байдаг.

Өөрөөр хэлбэл, эдгээр арга хэмжээ нь нийгмийн халамжийн хэрэгцээнд суурилдаггүй, харин алдар гавьяаг дагаж олгогддог тул нийгмийн халамжийн үндсэн зорилгод шууд хамааралгүй юм². Иймд халамжийн бодлого, хүн амын өсөлт, амжилтыг урамшуулан дэмжих бодлогыг ялгаж зааглах, халамжийн хуулиар зөвхөн зорилтот хэсэгт чиглэсэн арга хэмжээг тусгаж, халамжид хамааралгүй дээрх тусламж, урамшууллыг халамжийн хуулиас тусдаа хуулиар зохицуулахаар өөрчлөх шаардлагатай байна. Түүнчлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой зарим тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй нэгтгэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

¹ “Монгол улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд: Үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан, 2015 он, Жунко Ониши, Чулууны Тунгалаг, Дэлхийн Банкны Групп

² Эдвардо нарын тайлан, 2016 он, Дэлхийн Банкны Групп

Нийгмийн халамжийн одоогийн тогтолцоо нь үрэлгэн, их зардалтай байгаа хэдий ч ядуурлыг бууруулахад төдийлөн нөлөөлөхгүй байна. Тухайлбал, 5 ам бүлтэй нэн ядуу өрхөд (2 том хүн, 3 хүүхэдтэй) сард 45.5³ мянган төгрөгийн хүнсний эрхийн бичгийн дэмжлэг үзүүлж байгаа нь ядуу өрхийн сарын амьжиргааны хэрэглээний дунджаар 9.8 хувьтай тэнцэж байна. Энэ нь дэлхийн ихэнх улс орнуудтай харьцуулахад 2-3 дахин, Европ, Төв Азийн зарим улс орнуудтай харьцуулахад 5-6 дахин бага байна⁴.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнээс өөр амьжиргааны түвшинтэй уялдуулж зорилтот хэсэгт үзүүлж байгаа хөтөлбөр байхгүй байна. Иймд одоогийн хөтөлбөрүүдийн зорилго чиглэлийг өөрчилж зорилтот хэсэгт чиглүүлэх замаар хамрах хүрээг оновчтой болгох, тэдэнд очих тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааг нь хангах хэмжээнд хүргэх шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн нийт хөтөлбөр, арга хэмжээнд 2019 оны байдлаар давхардсан тоогоор 2.4 сая хүн хамрагдсанаас хүүхдийн, жирэмсэний, хүүхдээ асарч байгаа эхийн, одонтой эхийн зэрэг нийтлэг мөнгөн тусламжид хамрагдаж байгаа иргэдийг хасвал нийт халамжийн чиглэлийн хөтөлбөрт 812.5 мянган иргэн хамрагдсан байна⁵. Үүнээс хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх боломжтой иргэд 13 хувь буюу 100.0 мянган иргэн байна. Гэтэл нийгмийн халамжид хамрагдаж байгаа хөдөлмөр эрхлэх боломж дутмаг зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамруулж амьжиргааг дэмжих, ажлын байртай болгох нийгмийн халамжийн үйлчилгээ дутмаг байна⁶.

Иймд хөдөлмөрлөх чадвартай боловч халамж хүртдэг иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн шинэ төрлийн үйлчилгээнд хамруулах, халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг уялдуулах шаардлагатай байна. Түүнчлэн нийгмийн халамжийн арга хэмжээ, хөтөлбөрт хамрагдах хугацаа, эсхүл дараагийн арга хэмжээ, хөтөлбөрт шилжүүлэх талаарх зохицуулалтуудыг хуульд тодорхой тусгаагүйгээс насан туршдаа халамжлуулах сэтгэлгээг бий болгож байгаа дутагдалтай байна.

Иргэдийн хувьд нийгмийн халамжийн олон төрлийн арга хэмжээ, үйлчилгээ тус бүрд баримт материал бүрдүүлэх шаардлагатай болдгоос гадна санал болгож байгаа арга хэмжээ, хөтөлбөр, үйлчилгээнд хяналт шалгалт хийхэд санхүүгийн болон хүнийн нөөцийн хувьд хүндрэл үүсэж байна. Иймд нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж давхардлыг арилгах, иргэний талаарх төрд байгаа мэдээллийг тухайн иргэнээс шаардахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээ, арга хэмжээнд хамруулах, зарцуулалтад цахимаар хяналт тавих, дүн шинжилгээ хийх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд тэтгэвэр, тэтгэмж олгох хөнгөлөлт, тусламж үзүүлэх зэрэг бэлэн мөнгөний үйлчилгээ давамгайлж, өрх иргэдийг чадавхжуулах, сургах, зөвлөх, дэмжих нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг хүргэх

³ 2017 онд мөнгөн дүнг нэмэгдүүлснээр 56 мянган төгрөг болж нэмэгдсэн.

⁴ Эдвардо нарын тайлан, Дэлхийн Банкны Групп

⁵ Нийгмийн халамжийн сангийн тайлан 2019 оны тайлан

⁶ Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн ерөнхий нөхцөл байдал 2016 он, Людовико Карраро, Б.Энхцэцэг

эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалан нийгмийн халамжийн нийт санхүүжилтийн нэг хүрэхгүй хувийг энэ арга хэмжээнд зарцуулж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулахтай холбогдуулан нийгмийн ажилтны албан өрөөндөө иргэнийг хүлээн авч цаасан материал бүрдүүлж, архивлах зэрэгт зарцуулдаг хугацаа багасч, халамж шаардлагатай иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг нийгмийн ажлын үйлчилгээнд илүү хугацаа зарцуулах боломжтой болох тул нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг хүргэх эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Монгол Улсад нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамрагдаж байгаа нийт иргэдийн мэдээллийн сан (WAIS)-г⁷ 2016 оноос хэрэглээнд нэвтрүүлсэн. Түүнчлэн Орлогыг орлуулан тооцох аргачлалд суурилсан Монгол Улсын нийт өрхийн амьжиргааны түвшний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн бодлого, хөтөлбөрт ашиглаж байна. Ялангуяа нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдагсдын мэдээллийн сангаас мэдээлэл авах, солилцох, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Иймд нийгмийн халамжийн бүртгэл мэдээллийн тогтолцоо, түүнийг удирдах, ашиглах, бусад төрийн байгууллагатай мэдээлэл солилцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу хуулийн бүтэц уялдаа өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо зэрэг нийгмийн халамжийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл 9 бүлэгтэй байх бөгөөд зарчмын шинжтэй дараах зохицуулалтуудыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт, хуулийн зорилтыг тодорхойлж, нэр томъёоны хүрээг өргөтгөж, нийгмийн халамжийн хамрах хүрээ, нийгмийн халамжийн арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт, нийгмийн халамжийн нэр төрлийг нэгтгэн багцлах зорилтод нийцүүлэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн төрлийг тодорхойлж, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа, түүнийг олгохтой холбогдох харилцааг зохицуулна.

Амьжиргааны түвшин нь дунджаас дээгүүр ахмад настан нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй бол тэдний авах нийгмийн халамжийн тэтгэврийн

⁷ Welfare Administration Information System

хэмжээ нь ядуу болон дундаж амьжиргаатай нийгмийн халамжийн тэтгэвэр авагч ахмад настны тэтгэврийн хэмжээнээс ялгаатай тогтооно.

Нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг хөдөлмөрийн чадвараа 50-69 хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэх бодлогоор дэмжих, харин 70 ба түүнээс дээш хувиар алдсан иргэнд орон сууцны хөлс төлөх, түлш худалдах авахад зориулан жилд нэг удаа олгодог мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн тэтгэвэртэй нэгтгэж, тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлттэй уялдуулан тухай бүр нэмэгдүүлнэ.

Асаргааны тэтгэмжийн хувьд байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмж, тусламжийг хэвээр үлдээн харин байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настны асаргааны тэтгэмж, улирлын тэтгэмжийг нэгтгэн хэмжээг одоогийн авч байгаагаас бууруулахгүйгээр тогтоож, байнгын асаргаа шаардлагатай иргэний өвчин, эмгэгийн нөхцөлөөс хамаарч хэмжээ нь ялгаатай байхаар зохицуулна.

Гуравдугаар бүлэгт, нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, хөнгөлөлт олгохтой холбоотой харилцааг зохицуулна. Энэ хүрээнд байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн үед шаардлагатай дэмжлэг, тусламжийг тодорхой хугацаанд үзүүлэх, түүнчлэн зорилтот өрх, иргэний онцлог хэрэгцээнд үндэслэсэн боловсрол, эрүүл мэнд болон хүнсний дэмжлэг, амьжиргааны тусламжийг нөхцөл, шалгууртайгаар тодорхой хугацаанд олгохоор зохицуулна.

Дөрөвдүгээр бүлэгт, нийгмийн үйлчилгээ түүний хамрах хүрээ, төрөл, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах бөгөөд нийгмийн халамжийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ, олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ, асрамжийн үйлчилгээ гэсэн гурван төрөлтэй байна.

Халамжийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээнд зорилтот өрх, иргэний санал хүсэлтэд үндэслэн тэдний хэрэгцээнд нийцсэн зөвлөгөө, мэдээлэл өгөх, чиглүүлэх, холбон зуучлах зэрэг нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, хэрэгцээт нийгмийн үйлчилгээний багцыг тодорхойлж, өрхийн гишүүнтэй хамтран өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхээр зохицуулна.

Түүнчлэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэр төрлийг өөрчлөн сайжруулж, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх шинэ үйлчилгээг бий болгож, хамрагдаж байгаа халамж хүртэгч иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх боломжийг тусгана.

Тавдугаар бүлэгт, нийгмийн халамжийн сан, түүний төрөл, орлогын эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалт, тайлан тэнцэл гаргах, тайлагнахтай холбоотой харилцааг тусгана.

Зургаадугаар бүлэгт, нийгмийн халамжийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, тогтолцоо, нийгмийн ажилтан болон нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрх, үүрэг, амьжиргааг дэмжих зөвлөл, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний эрх үүрэгтэй холбогдох харилцааг тусгана.

Долдугаар бүлэгт, нийгмийн халамжийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг тусгана.

Наймдугаар бүлэгт, нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдагсдын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим тогтолцоо, түүний хадгалалт, хамгаалалт, харилцан мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг тусгана.

Есдүгээр бүлэгт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээг зогсоох, сэргээх, суутгал хийх болон хууль тогтоомж зөрчигчид холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх талаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцооны хамрах хүрээ нь оновчтой, зорилтот бүлэгт чиглэсэн, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байж, үйлчилгээ нь иргэдийн идэвх, сонголтод тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдсан, уян хатан, чанартай, хүртээмжтэй болно.

Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрлүүдийг оновчтой тогтоон зарим хөнгөлөлт, тусламжийг нэгтгэн багцалснаар өрх, иргэнд олгогдож байсан тэтгэмж, үйлчилгээний давхардал арилж, халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай ядуу иргэдэд чиглэсэн дэмжлэгт илүү хөрөнгө хуваарилагдах, тэдний амьжиргаанд эерэг нөлөө үзүүлэх боломжтой болно.

Халамжид зарцуулж байгаа нийт зардлыг огцом бууруулахгүйгээр, одоогийн халамжийн төсвийн хүрээнд дахин хуваарилалт хийж, халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай ядуу иргэдэд чиглэсэн дэмжлэгт илүү хөрөнгө хуваарилах зарчим баримтлах тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт аль болох ачаалал үүсгэхгүй зарчим баримтална.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн талаарх

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн халамжийн тухай, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл боловсруулж, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Хүүхэд хамгааллын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай, Сургуулийн өмнөх

боловсролын тухай, Эрүүгийн хуульд тус тус өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---